

**ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРОО /ЭМИЙН ҮНИЙН ӨСӨЛТИЙН ШАЛТГААН,
НӨХЦӨЛИЙГ ХЯНАН ШАЛГАХ/-НЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА
2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр, Даваа гараг**

Хуралдааны тэмдэглэлийн агуулга

<i>Хуралдааны товч тэмдэглэл:</i>	<i>1-3</i>
<i>Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:</i>	<i>4-6</i>
<hr/>	
<i>1.Түр хорооны тогтоолын төсөл /Түр хорооны сонсгол товлон зарлах тухай/</i>	<i>4-5</i>
<i>2.Түр хорооны тогтоолын төсөл /Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай/</i>	<i>5-6</i>

Монгол Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы Хянан шалгах түр хороо /Эмийн үнийн өсөлтийн шалтгаан, нөхцөлийг хянан шалгах/-ны 04 дүгээр сарын 08-ны өдөр /Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 7 гишүүнээс 4 гишүүн хүрэлцэн ирж, 57.1 хувийн ирцтэйгээр хуралдаан 12 цаг 19 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: Ц.Сандаг-Очир;

Эмнэлгийн чөлөөтэй: Д.Батлут.

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн хэлэлцэх асуудлын нэгдүгээрт орсон “Сонсголд гэрч дуудах тухай” Түр хорооны тогтоолын төслийг хаалттай горимоор хэлэлцэх горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 2

Татгалзсан: 2

Бүгд: 4

50.0 хувийн саналаар горимын санал дэмжигдсэнгүй.

Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны “дэмжсэн” санал техникийн саатлын улмаас “эсрэг” гарсан тул дээрх санал хураалтыг хүчингүй болгож, дахин санал хураалт явуулах горимын санал гаргав.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ц.Тувааны гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 3

Татгалзсан: 1

Бүгд: 4

75.0 хувийн саналаар дэмжигдлээ.

Ж.Чинбүрэн: Улсын Их Хурлын гишүүн Ж.Чинбүрэнгийн гаргасан горимын саналыг дэмжье гэсэн санал хураалтыг дахин явуулья.

Зөвшөөрсөн: 4

Татгалзсан: 0

Бүгд: 4

100 хувийн саналаар горимын санал дэмжигдсэн тул хуралдааныг хаалттай горимд шилжүүлэв.

Хуралдаан 12 цаг 23 минутаас 13 цаг 18 минутад хаалттай горимоор үргэлжлэв.

Нэг.Түр хорооны тогтоолын төсөл /Түр хорооны сонсгол товлон зарлах тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, Ц.Отгонбаатар нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: “Түр хорооны сонсгол товлон зарлах тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 0
Бүгд: 5
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хоёр.Түр хорооны тогтоолын төсөл /Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай/

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хяналт шалгалт, үнэлгээний газрын Хяналт шалгалтын хэлтсийн ахлах зөвлөх Ч.Онончимэг, Төсвийн хяналт, шинжилгээний хэлтсийн референт Д.Гэрэлт-Од, Ц.Отгонбаатар нар байлцав.

Хянан шалгах түр хорооны дарга Ж.Чинбүрэн “Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг танилцуулав.

Тогтоолын төсөлтэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүдээс асуулт, санал гараагүй болно.

Ж.Чинбүрэн: “Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай” Хянан шалгах түр хорооны тогтоолын төслийг батлах санал хураалт явуулья.

Зөвшөөрсөн: 5
Татгалзсан: 0
Бүгд: 5
100 хувийн саналаар тогтоол батлагдлаа.

Уг асуудлыг 13 цаг 21 минутад хэлэлцэж дуусав.

Хянан шалгах түр хорооны нээлттэй хуралдаанаар 2 асуудал хэлэлцэв.

Нээлттэй хуралдаан 08 минут үргэлжилж, 7 гишүүнээс 5 гишүүн хүрэлцэн ирж, 71.4 хувийн ирцтэйгээр 13 цаг 22 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ХЯНАН ШАЛГАХ ТҮР
ХОРООНЫ ДАРГА

Ж.ЧИНБҮРЭН

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ
ХӨТЛӨХ АЛБАНЫ ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2024 оны 04 дүгээр сарын 08-ны өдөр,
Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар”
танхим 12 цаг 19 минут.

ХЯНАН ШАЛГАХ ТҮР ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Ж.Чинбүрэн: Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны 24 оны 4 дүгээр сарын 8-ны өдрийн хуралдаан эхлэхэд ирц хүрсэн тул эхэлье. Хуралдааны ирцийг танилцуулна. Хуралдаанд, энэ дээр нөгөө юу гардаг чинь хааччихсан бэ? Хуралдаанд ирсэн гишүүдээ танилцуулъя. Туваан гишүүн ирсэн байна, Бейсен гишүүн ирсэн, Жаргалмаа гишүүн юугаа хуруугаа хий, орсон юм уу? Тийм Жаргалмаа гишүүн ирсэн байгаа. Тийм байна орсон байна. Чинбүрэн миний бие иржээ. Ингээд ирц 57,1 хувь буюу хуралдаан эхлэх ирцэд хүрснийг мэдэгдье.

Өнөөдрийн хуралдаанаар дараах асуудлыг хэлэлцэнэ. 1 дэх асуудал Түр хорооны сонсголд гэрчээр дуудах иргэн, албан тушаалтны нэрс батлах тухай тогтоолын төсөл. Энэ 2 дахь сэдэв Түр хорооны сонсгол товлон зарлах тухай тогтоолын төсөл. 3-д Нотлох баримтыг шинжлэн судлах, дараалал тогтоох тухай тогтоолын төсөл гэсэн ийм 3 асуудлыг хэлэлцэхээр бэлдсэн байгаа.

Түр хорооны сонсголд гэрчээр дуудах иргэн, албан тушаалтны нэрс батлах тухай тогтоолын төсөл гэсэн энэ хэсгийг бас хаалттай горимоор хуралдчихъя гэсэн ийм саналтай байна. Түр хорооны дуудах гэрч нарын нэрсийг хэлэлцэхэд хувь хүний нууц, хяналт шалгалтын үр дүнтэй холбоотой асуудлыг хэлэлцэх учраас хуралдааныг хаалттай горимоор явуулах саналыг гаргаж байна. Иймд Монгол Улсын Их

Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2, 12.3 дахь хэсгийг тус тус үндэслэн хуралдааныг хаалттай горимд шилжүүлэх горимын саналыг санал хураалт явуулъя. Тийм кнопоор, нийт. Туваан гишүүний микрофоныг нээнэ үү. Туваан гишүүний микрофоныг.

Ц.Туваан: Сая хаалттай горимд шилжүүлэхийг дэмжиж санал өгсөн боловч энэ төхөөрөмж буруу гарчихлаа. Тэгэхээр энэ санал хураалтыг цуцалж, ахин санал хураалт явуулж өгөхийг хүсье.

Ж.Чинбүрэн: Цуцалъя гэсэн Туваан гишүүний саналын дагуу санал хураалт явуулъя. 75 хувийн саналаар санал дэмжигдлээ. Тэгье яг үнэн, юуг нь сольчихъё. Ингээд дахин санал хураалт явуулна. Хаалттай горимд шилжүүлэн хуралдах саналыг дэмжье гэсэн горимоор санал хураалт явуулъя. Бид эхний асуудлаа л хаалттай горимоор явчихна. Гэрчийн нэрс гэдэг дээр тийм ээ. 100 хувийн саналаар дэмжигдлээ.

Ингээд хурлаа хаалттай горимд шилжүүлье. Хаалттай горимд шилжүүлэх зуур, гишүүдийн 100 хувийн саналаар горимын санал дэмжигдэж, хуралдааныг хаалттай горимд шилжүүлж байна. Та бүхэнд тогтоолын төслийг тараасан байгаа.

12.23 цаг

Хуралдаан 12 цаг 23 минутаас 13 цаг 18 минутад хаалттай горимоор үргэлжлэв.

**Нэг.Түр хорооны тогтоолын төсөл
/Түр хорооны сонсгол товлон зарлах
тухай/**

Ж.Чинбүрэн: Тогтоолын төсөл. Та бүхэнд уншаад танилцуулчихъя. Хаана байна вэ? Нөгөө юундаа л зарлая гэж байгаа шүү дээ 4 сарын 15, 16, 17-ндөө

зарлана гэдгээ л батлах гэж байгаа юм. Болчихсон уу? Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай.

Монгол Улсын Их Хурлын хянан шалгах түр хорооны тогтоол. Түр хорооны сонсголыг товлон зарлах тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 45 дугаар зүйлийн 45.1 дэх хэсэг, 46 дугаар зүйлийн 46.1 дэх хэсгийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 2023 оны хянан шалгах түр хороо байгуулах тухай 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Эмийн үнийн өсөлтийн шалтгаан нөхцөлийг хянан шалгах үүрэг бүхий Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг эмийн хүртээмж, үнэ, чанарын асуудал сэдвийн хүрээнд 2024 оны 4 дүгээр сарын 15-наас 17-ны өдрүүдэд зохион байгуулахаар товлосугай.

2.Хянан шалгах түр хорооны нотлох баримтыг шинжлэн судлах сонсголыг товлосонтой холбогдуулан хэвлэл мэдээллийн хэрэгслээр нийтэд мэдээлж, сонсголын бэлтгэл, зохион байгуулалтыг хангаж ажиллахыг Хянан шалгах Түр хорооны дарга Чинбүрэнд даалгасугай. Хянан шалгах түр хорооны дарга Чинбүрэн гэсэн байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой асуулт асуух, санал хэлэх гишүүд байна уу? Алга байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалт явуулъя. 100 хувийн саналаар тогтоолын төсөл батлагдлаа. Ингээд тогтоолын нээлттэй сонсголоо 15, 16 17-нд хийхээр тогтоол батлагдлаа.

13.21 цаг

Хоёр.Түр хорооны тогтоолын төсөл /Нотлох баримт шинжлэн судлах дараалал тогтоох тухай/

Дараагийн асуудал руу оръё. Нотлох баримтыг шинжлэн судлах дараалал тогтоох тухай. Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлийн 39.1 дэх хэсэг, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1 дэх хэсэг, 36 дугаар зүйлийн 36.4 дэх хэсэг, 45, 47, 48, 49, 50, 51, 52, 53, 54, 58 дугаар зүйлийг тус тус үндэслэн Монгол Улсын Их Хурлын 23 оны Хянан шалгах түр хороо байгуулах тухай 60 дугаар тогтоолоор байгуулагдсан Улсын Их Хурлын Хянан шалгах түр хорооноос тогтоох нь:

1.Нотлох баримтыг шинжлэн судлах дарааллыг хавсралтаар баталсугай.

2.Нотлох баримтыг шинжлэн судлах дарааллын баримталж, сонсголын дэгийг сахиулахыг Хянан шалгах түр хорооны дарга Чинбүрэнд даалгасугай. Хянан шалгах түр хорооны дарга Чинбүрэн гэсэн ийм тогтоолын төслийг батлахаар та бүхэнд танилцуулж байна.

Тогтоолын төсөлтэй холбоотой санал, асуулт байна уу? Түрүүн ярьчихсан учраас тодорхой байгаа тийм ээ. Санал, асуулт алга байна. Тогтоолын төслийг баталъя гэсэн санал хураалтыг явуулъя. 100 хувийн саналаар тогтоолын төсөл дэмжигдлээ. Ингээд тогтоолыг баталсанд тооцъё.

13.22 цаг

Ингээд өнөөдрийн хуралдаанаар хэлэлцэх асуудлаа хэлэлцээд дууслаа. Хуралдаа оролцсон Түр хорооны гишүүддээ баярлалаа. Би Түр хорооны гишүүдээс хүсэж байгаа зүйл нөгөө тов зарласантай холбоотой хэвлэл мэдээллийн ажилтнууд бас хэвлэлийн

хурал байж байна. Та бүхнийг хэвлэлийн хуралд бас хамт оролцохыг урьж байна.

Шууд одоо, цугларчихсан байна, шууд.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ
ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ*

БУУЛГАЖ, ХЯНАСАН:

ШИНЖЭЭЧ

Д.УЯНГА

